



**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2024 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Дархан-Уул аймаг.

2024.06.06

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**
(2024 оны эхний хагас жил)

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100	0.6	4,85
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	86		
	3.Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	100		
	4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	100	0.2	
	2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /СХЗГазрын даргатай байгуулсан гэрээ/	95,0		
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100		
	3. Хэрэглэгчийн үнэлгээ	92,13		
Ерөнхий үнэлгээ:			1,0	

ХЯНАСАН:

ДАРГА

Б.ЦЭВЭЭНДОРЖ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН

АХЛАГЧ

Б.БАЯРБААТАР

ГИШҮҮН

М.АНАНДА

Д.БОЛОРТУЯА

С.РЭНЧИНСҮРЭН

Ч.БАРХАС

И.АЛТАНЧИМЭГ

Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

(Нийт үнэлгээний 60%)

Стандарт, хэмжилзүйн хэлтэс нь 2024 оны эхний хагас жил дараах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 4 заалт,
 - Хэмжил зүйн тухай хуулийн 3 заалт,
 - Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 2 заалт,
 - Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолын 2 заалт,
 - Засгийн газрын 2022 оны 102 дугаар тогтоолын 1 заалт,
 - Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 2 заалт,
 - Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолын 1 заалт,
 - Засгийн газрын 2020 оны 106 дугаар тогтоолын 2 заалт,
 - Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолын 1 заалт,
 - Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 заалт,
 - Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 11 заалтыг хяналтад аван хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2024 оны эхний хагас жилийн байдлаар 100%-ийн хэрэгжилттэй, 5,0 онооны үнэлгээтэй байна.

Дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж, 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

2. Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 4 зорилт, 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 1 арга хэмжээ (Хэмжил зүйн чиглэлээр салбар лаборатори байгуулна) тус хэлтэст хамааралгүй заалт байна.

5 арга хэмжээ хэрэгжүүлснээс 100%-ийн хэрэгжилттэй 4, 30%-ийн хэрэгжилттэй 1 буюу 4,3 онооны үнэлгээтэй гарсан.

Дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж, 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

3. Дархан-Уул аймгийг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд 1 зорилт, 1 арга хэмжээг 100%, 5 онооны үнэлгээтэй хэрэгжүүлж, дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж, 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 3 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлснээс биелэлтийг тооцох хугацаа болоогүй 1, 6 заалт 100%-ийн биелэлттэй буюу 5 оноотой хэрэгжүүлж, тайланг маягтын дагуу гарган албан бичгээр болон цахимаар хүргүүлсэн.

Хоёр. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

(Нийт үнэлгээний 20%)

1. Засгийн газрын гишүүн, аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Монгол Улсын Шадар сайд, Дархан-Уул аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 9 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахад 3 арга хэмжээ хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 6 арга хэмжээ 100%-ийн хэрэгжилттэй, 5,0 онооны үнэлгээтэй хангаж дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 13 зорилт, 60 арга хэмжээг эхний хагас жилийн байдлаар 99,7% буюу 4,98 онооны үнэлгээтэйгээр хэрэгжүүлж, биелэлтийг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж, 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Лабораторийн шинжилгээний суурь асуудлууд сургалтад 7, баталгаажуулалтын эрх олгох модуль-2 сургалтад 1, хэмжил зүйн мэргэшүүлэх сургалтад 3, Зохистой дадлууд (GHP, GMP,GAP) сургалтад 3, MNS ISO 19011:2016 Менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй сургалтад 6 албан хаагч, нийт 10 удаагийн мэргэшүүлэх сургалтад давхардсан тоогоор 22 албан хаагчийг хамруулж, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлөөс 14 удаа зохион байгуулсан 7:4:10, Стандарт хэмжилзүйн газраас 14 удаа зохион байгуулсан 7:3:10 цахим сургалтад хэлтсийн 22 албан хаагч хамрагдлаа. Мөн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд 5 удаагийн дотоод сургалт, 4 төрлийн бусад арга хэмжээг зохион байгуулан нийт албан хаагчдыг 100% хамрууллаа.

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудын цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь 69.2, албан хаагчдын нийгмийн асуудалд 1,7 сая төгрөг зарцуулсан.

Дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу хэвлэмэл байдлаар гаргаж, 2024 оны 06 сарын 06-ны өдрийн 113 дугаар албан бичгээр Стандарт хэмжилзүйн газарт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 114 дүгээр албан бичгээр аймгийн ЗДТГ-ын

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

Гурав. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

(Нийт үнэлгээний 20%)

1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээ

Тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хавсаргав.

2. Шилэн дансны хөтлөлтийн талаар

Төсөв өмч хөрөнгө мөнгө зарцуулалтай холбоотой 3 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 409,463.3 мянган төгрөгийн 17 гүйлгээ, 2023 оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр, 2024 оны батлагдсан төсөв, төсвийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгааны тайлбар холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд 82 удаа шилэн дансны нэгдсэн цахим сайтад, санхүүгийн ил тодын самбарт 8 удаа байршуулсан. Стандарт хэмжилзүйн газрын 2024 оны 05 дугаар сарын 17-ны 01/512 дугаар албан бичгээр “Шилэн дансны тухай хууль”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хүрээнд хяналт шинжилгээ хийхэд зөрчилгүй дүгнүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 05 сарын 17-ны өдрийн 01/512 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр Дархан-Уул аймаг нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан тухай мэдэгдсэн.

3. Хэрэглэгчийн үнэлгээ

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсээс иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор хэрэглэгчдийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааг цахимаар болон хэвлэмэл байдлаар байнга авч үйл ажиллагааныхаа шаардлагыг сайжруулах арга хэмжээг авч ажилладаг.

Судалгаанд хэмжих хэрэгсэл баталгаажуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын үнэлгээ хийлгэх, гэрчилгээ авах, стандарт захиалах, үнэт металлын сорьц тогтоох лабораториор үйлчлүүлэх, мэдээлэл зөвлөгөө авах үйлчилгээ авсан, итгэмжлэгдсэн сорилтын лабораторийн үйлчилгээ авсан, “Стандарт ба хөгжил” хэлэлцүүлэгт оролцсон, 4 суманд хийсэн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчдаас давхардсан тоогоор цаасаар 534, цахимаар 19, нийт 553 санал хэрэглэгчдийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан.

Нийт 553 сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ дунджаар 92,13% маш сайн, 7,6% сайн, 0,7 % дунд гэж үнэлсэн байна. Энэ нь 2023 оны жилийн эцсийн сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулахад 0.33%-р өссөн дүнтэй байна.

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ МӨРӨӨР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АЖИЛ

Ерөнхий боловсролын 300 сурагч, их дээд сургуулийн 500 гаруй оюутнууд, нийт 800 гаруй хүүхэд багачуудад Стандарт, Хэмжил зүйн талаар мэдлэг олгох сургалт хийсний зэрэгцээ Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг байгуулан, үүний хүрээнд 2023 онд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн бүх ерөнхий боловсролын сургуулиудын бага, дунд, ахлах ангийн 20 мянга гаруй сурагчдад, 2024 онд 17 мянга

гаруй сурагчдад Стандарт, хэмжил зүйн талаар мэдлэг мэдээлэл өгөх сургалтыг шат дараатай зохион байгуулан ажилласан.

Мөн орон нутгийн анхны онлайн радио “Эхлэл радио фм 87.9”-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан, иргэдийн Стандарт хэмжил зүйн салбарын тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 4 удаа подкаст хийж, фэйсбүүк болон youtube сувгаар нийтэд түгээж байна.

ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД

-Хэмжил зүйн ажил үйлчилгээнд ашиглах эталон тоног төхөөрөмж баазыг бэхжүүлэх, хэмжүүр баталгаажуулалтын цар хүрээг өргөжүүлэхэд нэн чухал шаардлагатай байгаа 1 ба 3 фазын цахилгааны тоолуур шалгах зөөврийн эталон, усан шахалттай даралтын пресс, электрон манометрийн хамт /MPa, Bar, kgc/cm², kPa, H₂O/ эталон төхөөрөмжүүдийг шинээр бий болгох

-masm.gov.mn/da/ сайтын нүүр хэсэгт хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авах цонх нэмэх

-“Цахим сургалтын танхим”-ын сургалтын ширээг шинэчлэх, дагалдах хэрэгслүүд болох микрофон, камер, индэр зэргийг шинээр авч байршуулах

-Сорилтын лабораторийн итгэмжлэлийн хугацаа дууссантай холбоотой тус хэлтсээс 2024 оны 03-р сард итгэмжлүүлэх хүсэлтийг Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлсэн ба 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 4-р сарын 15-ны өдөр ирж сорилтын лабораторийн ажлын байртай танилцаж улмаар ажлын байр нь Орон сууцны тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж болон холбогдох стандартын шаардлагад нийцэхгүй байгаа тул түр түдгэлзүүлсэн тухай мэдэгдлийг Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2024 оны 04 сарын 16-ны өдрийн 01/66 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Иймд тус хэлтсийн сорилтын лабораторийг зориулалтын ажлын байртай болгох асуудлыг шийдвэрлэж өгөх

-Сорилтын лабораторид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд нь техник технологийн хоцрогдолд орсон, элэгдэж хуучирсан, анги нарийвчлал муу болсон тул шинжилгээ хийхэд шаардлагатай орчин үеийн багаж, тоног төхөөрөмжүүдээр хангаж өгөх

-Эзэлхүүн, хий шингэний улсын шалгагч нарын ажлын байрны нөхцөлийг хэвийн бус нөхцөлд оруулах. /Хавар, намрын улиралд буюу шатахуун түгээх станц, авто хий цэнэглэх станцын баталгаажуулалтын үед хор саармагжуулах бүтээгдэхүүн олгож байх. (Тухайн үедээ маш ихээр хордож нүүр гар биеээр тууралт өгөх, дотор муухайрч толгой манарах шинж илэрдэг.)

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Б.ЦЭВЭЭНДОРЖ

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН

АХЛАГЧ

Б.БАЯРБААТАР

ГИШҮҮН

М.АНАНДА

Д.БОЛОРТУЯА

С.РЭНЧИНСҮРЭН

Ч.БАРХАС

И.АЛТАНЧИМЭГ